



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/19

Чингис хот

Тусгай зөвшөөрөл олгох,
нэр солих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3.5, 19.3.8, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 10 дугаар зүйлийн 10.1.1, 12 дугаар зүйлийн 12.1, 16 дугаар зүйлийн 16.2, 16.2.2, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны 2018 оны 53 дугаар тогтоолын 5.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж буй "Азифарм Хайрхан тун" эм эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллагад мансууруулах сэтгэцэд нөлөөлөх эмээр хангах тусгай зөвшөөрөл, Зооноз өвчин судлалын төвд ахуйн мэрэгч устгах, халдваргүйжүүлэлтийн үйлчилгээний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, Дэлгэрхаан суманд үйл ажиллагаа явуулж буй Арьсны өвчин судлалын үндэсний төвийн харьяа Аварга тосон рашаан сувиллын тусгай зөвшөөрлийг тус бүр 3 жилээр шинээр олгосугай.

2. Биндэр, Бэрх суманд үйл ажиллагаа явуулж буй сум дундын эмнэлгийн нэрийг Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/540 тушаалын дагуу А зэрэглэлийн сумын Эрүүл мэндийн төв болгон өөрчилсүгэй.

3. Дээрх эмнэлэг, эмийн сангийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Л.Мэндбаяр/-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын дарга бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010081